

С. Ишдорж

БНХАУ-ЫН 30 ЖИЛ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Одоогоос 30 жилийн өмнө Хятад оронд ардын хувьсгал ялж, БНХАУ байгуулагдсан билээ.

Орос оронд мандсан Октябрийн социалист их хувьсгалын нөлөөгөөр хятадын ард түмний хувьсгалт тэмцэл урьд өмнө үзэгдээгүй хүчтэй өрнөж, Хятадын Коммунист Нам байгуулагдан, Хятад оронд марксизм-ленинизмийн үзэл санаа дэлгэрсэн юм.

Олон улсын коммунист, ажилчны хөдөлгөөн шинэ шинэ амжилт олж, социалист хувьсгал түгэн дэлгэрч байсан нөхцөлд хятадын хөдөлмөрчин ард түмэн Хятадын Коммунист намаар удирдуулан империализмын ноёрхол, феодалын дарлалаас чөлөөлөгдөх, улс орныхоо олон зуун жилийн хоцрогдлыг арилгах, хөгжил, дэвшлийн замаар замнах замыг сонгон авчээ.

1925 оноос Хятад оронд өрнөсөн үндэсний хувьсгал болон хятадын ард түмнээс гадаад, дотоодын дайсны эсрэг явуулсан олон жилийн хувьсгалт тэмцлийг олон улсын ажилчин анги, коммунист хөдөлгөөн, Коминтерн, социализмын анхны хоёр орон-ЗХУ, БНМАУ зүйл бүрээр дэмжин тусалж байсан юм.

Хятадын ард түмний заналт дайсан империалист Японы цэргийн ихээхэн хүчийг зөвлөлт, монголын арми өөртөө татан барьж 1939 онд Халхын голын районд Японы эзэн хааны 6-р армийг, дэлхийн II дайны төгсгөлд Квантуны шилдэг армийг бутцохиж Зүүн хойт Хятад, Өвөр Монголыг чөлөөлснөөр Азийн улс түмэн, юуны өмнө хятадын ард түмний хувьсгалт тэмцэлд бодит дэмжлэг үзүүлсэн юм.

Дэлхийн II Дайны дараа америкийн империализм Хятадад өөрийн ноёрхлыг хэвээр байлгах зорилгоор Хятадын дотоод дахь дарлан мөлжигч ангиудтай эвсэн хуйвалдаж, Чан Кайшигээр толгойлуулсан харгис Гоминданы дэглэмийг дэмжин, цэрэг-эдийн засгийн ихээхэн тусламж үзүүлж, 1946-1949 онд Хятад оронд иргэний дэгдээсэн юм. гэвч хятадын хөдөлмөрчин ард түмэн ЗХУ-ын цэрэг-эдийн засгийн өгөөмөр тусламжинд тулгуурлан, улс орноо империализмын улс төр, эдийн засгийн ноёрхлоос ангижруулах, дарлан мөлжигч ангиудыг түлхэн унагаах, ардын засаг байгуулах тэмцэлд боссон билээ.

Зөвлөлт, Монголын арми милитарист японыг бутцохих шударга дайнд олзолж авсан үлэмжийн их зэр зэвсгийг Хятадын Ардын Чөлөөлөх Армид ямар ч үнэн төлбөргүйгээр шилжүүлэн өгч, хятадын хувьсгалыг дэмжсэнээс гадна ЗХУ болон ардын ардчилсан орнууд олон улсын тавцан дээр хятадын ард түмний эрх ашгийг тууштай хамгаалж, түүнд улс төр, дипломат, сэтгэл санааны өргөн дэмжлэг үзүүлсэн юм.

Хэдийгээр иргэний энэ дайны эхэн үед харгис Гоминданы арми түр зуурын амжилт олж байсан боловч байлдааны ажиллагааны явцад Хятадын Ардын Чөлөөлөх Арми санаачлагыг гартаа авч, Манжуурын нутагт дайсны цэргийг бутцохиж, давшилтаа үргэлжлүүлэн, улмаар Хятадын эх газрын нутгийг чөлөөлөн, хятадын ардын хувьсгалын ялалтыг хангав.

Хятад оронд ардын хувьсгал ялсан нь дэлхийн социализм, хувьсгалт хүчний амжилтын хэсэг байсан учраас түүнийг бүх дэвшилт хүн төрөлхтөн, түүний дотор монголын ард түмэн сэтгэл хангалттай талархан дэмжсэн юм.

Олон жилийн турш үргэлжилсэн хятадын ардын хувьсгал ийнхүү амжилттай ялсны хамгийн аятай таатай гадаад нөхцөл бол дэлхийн II дайнд ЗХУ, түүний зэвсэгт хүчин фашизмыг бутцохиход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсний дүнд дэлхийн социалист систем бүрэлдэн тогтож, 1949 он гэхэд америкийн империализмын атомын монополийг ЗХУ эцэс болгон, атомын зэвсгээр түрээ барьж «коммунизмыг таягдан хаях» гэсэн өрнөдийн бодлогод цохилт өгөөд улс түмний эрх чөлөөний тэмцэл, түүний дотор хятадын хувьсгалд бүх талын идэвхтэй дэмжлэг үзүүлсэн явдал мөн. ЗХУ болон ардын ардчилсан орнуудын энэ дэмжлэг л БНХАУ байгуулагдаж оршин тогтнохын найдвартай баталгаа болсон юм.

Хятадад хөрөнгөтөн, газрын эздийн харгис дэглэмийг түлхэн унагааж, БНХАУ-ыг тунхагласнаар хятадын хувьсгалын гол асуудал болох засгийн эрхийг хөдөлмөрчин ард түмний гарт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэжээ. Хятадад засаг төрийн байгуулал ажилчин анги, тариачид, үндэсний хөрөнгөтөн болон бусад эх оронч ардчилсан элементүүдийн нэгдсэн фронтын засгийн хэлбэрээр тогтож, түүнд ажилчин, тариачны холбоо шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх, коммунист нам хөдөлмөрчин олны эрх ашигт нийцсэн бодлого явуулах ёстой байлаа. Энэ бодлогыг боловсруулж явуулахад дэлхий дахины хэмжээгээр энх тайван, ардчилал, социализмын хүч давамгайлж байсан явдал, мөн ХКН-ын доторхи интернационалч хүчний үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэжээ. ХКН-ын доторхи Мао Зэдүн тэргүүтэй жижиг хөрөнгөтний үндсэрхэг үзэлтний төлөөлөгчид хэдийгээр нам, төрийн гол өндөр албан тушаалуудыг булаан авсан байсан ч гэсэн БНХАУ байгуулагдсаны дараахи эхний 10 шахам жил тэр үеийн нөхцөл байдлыг харгалзан ХКН-ын доторхи интернационалч хүчний үйл ажиллагааг даган, ардын засгийг цаашид хөгжүүлэх, ЗХУ болон социалист системийн орнуудтай найрамдал, хамтын ажиллагааг бэхжүүлэх, империализмын эсрэг олон улсын энх тайвны төлөө тэмцэх бодлогын чиг шугамыг хэрэгжүүлэхэд оролцож байв.

БНХАУ-ын хувьд ЗХУ болон социалист бусад орны явуулж, байсан интернационалч бодлого, үзүүлсэн ах дүүгийн тусламж онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1950 оны 2-р сарын 14-нд Москва хотноо байгуулсан Зөвлөлт Хятадын найрамдал, холбоо, харилцан туслах тухай гэрээ нь ЗХУ-аас БНХАУ-д улс төр, эдийн засаг, цэргийн тусламж үзүүлэх үүргийг заасан бөгөөд үүнийг ХКН-ын доторхи интернационалч хүч Хятадад социализм байгуулах хамгийн чухал нөхцөл мөн гэж үзэж байв.

БНХАУ байгуулагдсанаас хойш 1950-иад оны сүүлч хүртэлх эхний 10 шахам жилийн хугацаанд хятадын ард түмэн ЗХУ болон социалист бусад орны тусламж дэмжлэгт тулгуурлан ХКН-ын удирдлагын дор БНХАУ-д хувьсгалын ерөнхий ардчилсан зорилтыг амжилттай шийдвэрлэж, социализмын үндсийг тавих талаар их амжилт олсон юм.

БНХАУ байгуулагдсаны дараахи анхны 3 жил бол олон жилийн дайнд эвдэрч сүйдсэн хийгээд гадаадын империалистууд, хятадын хөрөнгөтөн, газрын эздийн дээд давхаргын тонон дээрэмдсэн аж ахуйг сэргээн босгох, хувьсгалын ерөнхий ардчилсан зорилтыг хэрэгжүүлэх үе байв. Эдгээр зорилтын дотроос хамгийн чухал нь газрын шинэтгэлийг хийж газрын эздийг ангийн хувьд устган, газаргүй буюу бага газартай 300 сая тариачинд 47 сая га газар олгож, тэднийг газар эзэмших хөлс-

нөөс чөлөөлсөн явдал юм. Газрын шинэтгэл нь хятадын тосгон дахь феодализмын үндсийг эцэс болгох, хөдөө аж ахуйг хамтын аргаар эрхлэх замыг нээсэн юм. Мөн улс монопольт («хүнд суртлын») капиталын хөрөнгийг хувааж, гадаадын капиталыг устгажээ. Хуучин төрийн оронд улсын шинэ аппарат бий болж, хувьсгалын эсэргүү нарыг дарж устган, үндэсний хөрөнгөтнүүдээс ардын засгийн арга хэмжээг эсэргүүцсэн элдэв оролдлогыг няцаасан нь үндэсний хөрөнгөтнүүдээс улс орны эдийн засагт эзлэх хувийн жин, үзүүлэх улс төрийн нөлөөг эрс бууруулжээ. Энэ бүхний дүнд Хятадын олон хэвшил бүхий эдийн засагт улсын салбарын нөлөө бэхжиж, ажилчин ангийн нэр хүнд, зохион байгуулалт өсч, түүнээс хятадын нийгмийн амьдрал, ХКН-ын чиг шугамд үзүүлэх нөлөө нэмэгджээ. Ажилчин ангийн роль өсөн нэмэгдэхэд ЗХУ болон социалист системийн бусад орноос БНХАУ-тай өргөжүүлэн хөгжүүлж байсан хамтын ажиллагаа шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. Гэвч Хятадын нийгэм-улс төрийн дотоод дахь гол тулгуур хүч нь тариачид болсон хэвээр, улс орны үйлдвэрлэх хүчний хөгжлийн нийт хэмжээ дорой, БНХАУ газар тариалангийн хоцрогдсон орон хэвээр байв. Хятадын эдийн засагт капитализмын өмнөх аж ахуйн хэлбэр зонхилж, ажилчин анги тооны хувьд цөөн, хүн амын ихэнх нь бичиг үсэг мэдэхгүй зэрэг байдал нь Хятадыг социализмд шилжих зорилтыг хэрэгжүүлэх явдлыг ээдрээтэй болгон хүндрүүлж байв. Гэхдээ сэргээн босгох үед хувьсгалын ерөнхий ардчилсан зорилтыг шийдвэрлэсэн явдал дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн улс төр, эдийн засгийн урьдчилсан нөхцлийг бүрэлдүүлсэн юм.

1953 оноос эхлэн хятадын ард түмэн ХКН-ын Төв Хорооноос боловсруулсан шилжилтийн үеийн зорилтыг хэрэгжүүлэх жанжин шугамыг биелүүлэх ажилд орсон юм. БНХАУ-д социализмын үндсийг тавих үеийн намын бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлохдоо, улс орныг социалист ёсоор аж үйлдвэржүүлэх, улс ардын аж ахуйн бүх салбарт социалист үйлдвэрлэлийн харьцааг ялуулах зорилтыг 15 жилийн турш (1953-1967) шийдвэрлэх, ЗХУ болон социалист бусад орны эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёлын тусламжинд түшиглэн Хятадыг аж үйлдвэр-хөдөө аж ахуйн социалист орон болгон хувиргах зорилтыг заажээ. ХКН-ын бодлогын энэ жанжин шугамыг амжилттай хэрэгжүүлэхийн хамгийн гол чухал нөхцөл бол хамтын удирдлагын зарчмыг заавал хэрэгжүүлж, намын удирдах ролийг хүчтэй болгон, ямар нэг хувь хүний ролийг хэт төвийлгөхгүй байх, түүнчлэн зөвлөлтийн туршлагыг эзэмшин, зөвлөлтийн тоног төхөөрөмж, мэргэжилтэн нарын тусламжийг авах явдал мөн гэж заажээ. ХКН-ын энэ жанжин шугам нь социалист хувьсгал, социалист байгуулалтын тухай марксист-ленинист сургаал дээр үндэслэсэн чиг шугам байв. Үүнийг амжилттай хэрэгжүүлэх явдал социалист орнуудтай хамтран ажиллаж, нийгмийн янз бүрийн байгуулалтай улсууд энх тайвнаар зэрэгцэн орших бодлогыг явуулах, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангахын төлөө тэмцэлтэй зүй ёсоор холбон тавьжээ. Хятадын хувьд социализмд шилжих хугацаа зайлшгүй удаан үргэлжилж социализмын материал-техникийн баазыг байгуулах, социалист өөрчлөлтийг хийх, улс орныг зохих үе шат дамжуулан, бодит төлөвлөгөөний үндсэн дээр хөгжүүлэхэд гол анхаарлаа хандуулахыг ХКН-ын Төв Хорооны баримт бичигт тэмдэглэн заасан байна.

Улс орныг социалист ёсоор хөгжүүлэх программыг тодорхойлсон намын энэхүү жанжин шугамыг боловсруулсан нь ХКН-ын доторхи интернационалч хүчний том амжилт болсон бөгөөд түүнийг 1954 оны 9-р сард Бээжин хотноо хуралдсан Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Хурал (БХАТХ)-ын анхдугаар чуулганаас баталсан Хятадын түүхэн дэх анх-

ны ардчилсан үндсэн хуульд тусган оруулсан юм. Хятад орныг социализмын замаар замнуулах намын жанжин шугамыг хэрэгжүүлэх зорилгод 1953-1957 онд БНХАУ-ын улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөө бүрэн дүүрэн нийцжээ. Анхдугаар таван жилийн төлөвлөгөөнд үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний гаргалтыг бараг 2 дахин, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 25 хувиар нэмэгдүүлэхээр зааж, металлурги, эрчим хүч, машин үйлдвэр зэрэг хүн аж үйлдвэрийн чухал салбаруудыг хөгжүүлэх буюу шинээр барьж байгуулах, түүнчлэн тээврийг хөгжүүлэх, ашигт малтмал хайгуулын ажлыг зохион явуулахад онцгой анхаарчээ. Анхдугаар таван жилд аж үйлдвэрийн томоохон 694 газар барьж байгуулахаар төлөвлөснөөс гол 156 үйлдвэрийн газрыг ЗХУ-ын тусламжаар барьж байгуулсан юм.

Социализм байгуулах намын жанжин шугамын хэтийн төлөвт урам зориг нь бадарсан хятадын ард түмэн анхдугаар таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө шургуу тэмцэл өрнүүлж, аж үйлдвэрийн шинэ барилга байгууламжийг барьж байгуулахад хүчээ төвлөрүүлжээ. Улс орны хөрөнгө борлуулалтын бараг 90 хувийг хүнд аж үйлдвэрийн салбарт зориулж, Баотоу, Уханийн металлургийн комбинат, Тайюань, Шэньяны машин үйлдвэрлэх завод, Шэньян болон Харбины багаж хэрэгсэл үйлдвэрлэх завод, Яньчунуны авто машин үйлдвэрлэх завод, Лояны тракторын завод зэргийг ЗХУ-ын тусламжтайгаар зөвлөлтийн сүүлийн үеийн техникээр тоноглон шинээр барьж байгуулжээ. Мөн ЗХУ-ын тусламжтайгаар Аньшаны металлургийн комбинат зэрэг аж үйлдвэрийн газрыг сэлбэх буюу өргөтгөн барьж байгуулах ажлыг өргөнөөр хийв. 1955 оны эцэс гэхэд БНХАУ-д 250 гаруй шинэ үйлдвэрийн газар ашиглалтанд орсон нь нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 25 хувь гаруйг үйлдвэрлэн гаргадаг болжээ. Анхдугаар таван жилийн төлөвлөгөөний эхний жилүүдийн эдгээр амжилт нь ЗХУ ба социализмын бусад орны эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн үлэмжийн их тусламжийн шууд үр дүн байсан бөгөөд аж үйлдвэрийн газар олноор баригдах дутам хятадын ажилчин ангийн эгнээ мэдэгдэхүйц өсч, хятадын нийт ажилчин, албан хаагчдын тоо 1955 онд 1952 оныхоос 2 гаруй дахин нэмэгдэж 24,5 сая хүн болсон байна.

Улс орныг аж үйлдвэржүүлж эхлэхийн зэрэгцээ намын жанжин шугамын дагуу хот, тосгонд социалист өөрчлөлтийг аажмаар хийж эхэлсэн байна. Мөн хувийн үйлдвэр, худалдаа, гар урчуудын болон улсын капитализмын асуудлыг шийдвэрлэж эхэлсэн юм.

Хятадын нийгмийн хамгийн ээдрээтэй хэцүү бөгөөд төвөгтэй асуудал болох хөдөө тосгоныг социалист ёсоор өөрчлөн байгуулах асуудлыг хэрхэн шийдвэрлэхээс олон зүйл хамаарагдах ёстой байв. Газрын шинэтгэл хийсэн нь дунд тариачдын тоог эрс олшруулж, тосгонд хувийн аж ахуйтнууд зонхилох болжээ. Хятадын хөдөө тосгоны ядуу дорой байдал нь социалист аж үйлдвэржилтийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын дорвитой эх булаг болж чадахгүй байлаа.

Хятадын бодит байдал, ялангуяа хөдөө аж ахуйн хоцрогдол нь цаг хугацаа, нийт ард түмний ихээхэн хүч чармайлт, нам, түүний удирдлагаас улс орны нийгэм-эдийн засгийн хөгжлийг шинжлэх ухааны үндэслэлтэй хангах талаар шургуу ажиллахыг зүй ёсоор шаардаж байв.

Харин 50-иад оны дундаас ХКН-ын дотоод улс төрийн байдал мэдэгдэхүйц хүндэрч намын удирдлагад Мао Зэдүний бүлэг намын жанжин шугамын эсрэг дайран довтолсон ажил явууллагаа эрс идэвхжүүлэв. Мао Зэдүн өөрийн хэлсэн хэд хэдэн үгэндээ Хятадад материал-техникийн бааз байгуулахгүйгээр коммунизмд шилжин орж болох юм гэсэн зүйлийг ярьж, намын жанжин шугамыг гуйвуулан, БНХАУ-д социализмыг 1959 он гэхэд байгуулах зорилтыг дэвшүүлж байв. Тэр хэлэхдээ хятадын та-

риачид онцгой их хувьсгалт уламжлалтай мэт ярьж, Хятадыг «юу ч бичээгүй цэвэр цагаан цаас» мэт дүрслэн, хоцрогдол, ядуу зүдүү байдлын давуутай талыг нотолж «долгион мэт хөгжлийн тухай хууль» гэгчийг номлож, зөвлөлтийн туршлагыг шүүмжилж, Хятад өөрийн атомын бөмбөгтэй болохыг илт уриалжээ. Хятад орныг шинжлэх ухааны социализмын замаас хазайлгах гэж Мао Зэдүнээс ХКН-ын VIII их хурал болохын өмнө хийсэн энэ оролдлого бүтэлгүй болсон юм.

Хятадын ард түмэн анхдугаар таван жилийн төлөвлөгөөг амжилттай биелүүлсэн туршлага нь БНХАУ социалист орнуудтай улс төр, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг өрнүүлсэн нөхцөлд социализмын үндсийг амжилттай тавьж болохыг тод харуулсан юм.

1956 оны 9-р сард хуралдсан ХКН-ын VIII их хурал хятадын ард түмний амьдралд онцгой ач холбогдолтой үйл явдал болсон билээ. Энэ их хурал БНХАУ-ыг 1958—1962 онд хөгжүүлэх хоёрдугаар таван жилийн төлөвлөгөөний эдийн засгийн өргөн программыг дэвшүүлсэн юм. ХКН-ын VIII их хурлаар баталсан намын дүрмээс «хятадчилсан марксизм» буюу «Мао Зэдүний үзэл санаа» гэгчийг хасч, «Хятадын Коммунист Нам нь үйл ажиллагаандаа марксизм-ленинизмыг удирдлага болгоно»¹ гэж дурджээ. Тэр их хурал ЗХУ болон социалист лагерийн бусад оронтой ах дүүгийн найрамдал, нягт хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлж, тэдгээрийн тусламж дэмжлэгт түшиглэх явдлыг БНХАУ-д социализм амжилттай байгуулахын зайлшгүй шаардлагатай чухал нөхцөл мөн гэж үзсэн юм.

Хятадын гадаад бодлого ч БНХАУ байгуулагдсаны дараахи эхний 10 шахам жилд хэдийгээр ХКН-ын доторхи үндсэрхэг үзэлтний бүлэг их гүрний дээрэнгүй жанжлах эрмэлзлэлээ хэрэгжүүлэх зорилгоор Солонгосын дайн болон Англи, Франц, Израилийн түрэмгийлэгчдээс Арабын Нэгдсэн Улсын эсрэг хийсэн дайны үед ЗХУ-ыг АНУ болон өрнөдийн бусад империалист гүрэнтэй мөргөлдүүлэх оролдлого хийж, 1957 оны коммунист, ажилчны намуудын Москвагийн зөвлөлгөөн дээр Мао Зэдүн өөрөө социализмыг империализмын эсрэг дэлхийн дайнд уриалсан өдөөн хатгасан үг хэлж байсан ч гэсэн бүхэлдээ ЗХУ болон социалист бусад орны тусламжийг үргэлжлэн авах шаардлагад захирагдан, тэдэнтэй хамтран ажиллах, олон улсын тавцан дээр империализмын эсрэг бодлого явуулж байв. БНХАУ Энэтхэгтэй хамтран энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчим («Панча-Шила»)-ыг тунхаглаж, Энэтхэг-хятадын хойгт энх тайван байдал тогтоосон 1954 оны Женевийн хэлэлцээрт оролцон, хэдийгээр ЗХУ болон манай улсыг гадуурхсан далдын муу санааны оролдлого хийсэн ч гэсэн колоничлолын эсрэг үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг дэмжиж улс хоорондын харилцааны чухал зарчим тунхагласан Ази, Африкийн 29 орны төрийн болон засгийн газрын тэргүүн нарын бага хурлыг 1955 онд Бандунг хотноо хуралдуулахад хувь нэмрээ оруулсан юм.

БНХАУ байгуулагдсаны дараах эхний 10 шахам жил (1949—1957 он)-д Хятадын Коммунист Нам үйл ажиллагаандаа үндсэндээ марксизм-ленинизмын зарчим, социалист байгуулалтын ерөнхий зүй тогтлын шаардлагыг өөрийн орны өвөрмөц нөхцөлд тохируулан хэрэгжүүлж, БНХАУ ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад оронтой нэг эгнээнд явж, олон улсын коммунист хөдөлгөөн, юуны өмнө түүний хамгийн хатуужил туршлага бүхий шалгарсан отряд ЗХУКН-тай нягт холбоотой байсан учраас улс орныхоо нийгэм-эдийн засгийг хөгжүүлэх талаар үлэмж их амжилт олж, улс түмний энх тайван аюулгүй байдлын эрх ашигт нийц-

¹ Материалы VIII всекитайского съезда Коммунистической Партии Китая. госиздат. Полит-литературы. М., 1956, 508-р тал.

сэн гадаад бодлого явуулж байв. Энэ үе нь хятадын ард түмний сонгож авсан социалист хөгжил дэвшлийн зам зөв байсныг тод харуулсан юм.

Гэтэл 1958 онд хятадын амьдралд эрс эргэлт гарав. Улс орны хөгжлийн явцыг «их үсрэлтийн» замаар түргэтгэх гэдэг нэрийдлээр Мао Зэдүний бүлэг ХКН-аас шилжилтийн үеийн социализм байгуулах жанжин шугамыг өөрчилж, орон даяар цэргийн хуарангийн дэглэм тогтоох чиг шугамыг баримтлах болов. Мао Зэдүн ахар богино хугацаанд Хятадыг цэргийн хүчирхэг гүрэн болгон хувиргах зорилт тавьж, гүүний гадаад улс, төрийн бодлогын гол зорилго нь дэлхий дахинд хятадын жанжлалыг тогтоох явдал мөн гэж үзжээ. Тэр өөрийн адал балмад «3 улаан туг» («жанжин шугам», «Их үсрэлт», «Ардын коммун»)-ийн бодлогыг явуулахдаа, Хятад улс 7—10 жилийн дотор ЗХУ, АНУ-ыг гүйцэж, «дэлхийн тэргүүний орон» болох тухай шууд ярьж, 60-аад оны сүүлч гэхэд хятадын цэргийн аж үйлдвэр нь Номхон далайг хяналтдаа авч Хятадын цэрэг Япон, Филиппин, Сан-Францискод десантаар бууж чадах нөхцлийг хангах, өөрөөр хэлбэл Хятад улс дэлхийг ноёрхохын төлөө тэмцэл хийх чадавхтай болох тухай заалт өгч байжээ. Тэр Хятадыг «цэргийн хүчирхэг гүрэн» болгон хувиргах бодлого, өөрийн адал балмад шинэ «жанжин шугам» гэгчээ «бүх хүчээ дайчилж урагшаа тэмүүлэн, социализмыг улам их түргэн, сайн, арвилан хэмнэх зарчмаар байгуулах» гэдэг лоозон гоор халхавч хийж, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн хөгжлийн «хэт түргэн хурдцыг» дур зоргоороо тулгасан юм. Маогийн «их үсрэлтийн» бодлогын мөн чанар нь албадлагын аргаар мэргэжлийн биш хүмүүсийн хөдөлмөрийг өргөн хэрэглэх замаар үр тариа, ган үйлдвэрлэлтийг эрс нэмэгдүүлэх, ингэснээр Хятадын эдийн засаг, юуны өмнө цэрэг-аж үйлдвэрийн чадавхийг ихзэхэн өсгөхөд чиглэжээ. Ялангуяа гар аргаар ган хайлуулахад гэрийн ширмэн тогоо, зуух, нэгэнт барьж байгуулсан төмөр замын ган шугамыг хуулж авч хэрэглэж байснаас гадна 90 сая гаруй хүнийг эрхэлсэн ажлаас нь холдуулж дайчлан ажиллуулж, 80 сая тонн нүүрс, 40 сая тонн төмрийн хүдрийг зарцуулаад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь чанарын хувьд үйлдвэрлэлд тэр хэвээр хэрэглэж болохгүй байв. Үүнээс болж 1958 оны үр тариакы арвин ургацыг бүрэн хурааж авч чадаагүй бөгөөд төв, орон нутагт нам, төр, аж ахуйн байгууллагын удирдах ажилтнуудын эрхэлсэн ажлын чигийг өөрчилснөөс улс ардын аж ахуй эмх замбараагүй байдалд оржээ. Мөн Мао Зэдүний заалтаар хэдхэн сарын дотор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 740 мянган хоршооллыг 26 мянган ардын коммун болгон өөрчилж байгуулан, коммунуудад тариачдын хэсэг газар, амины мал, тэжээвэр шувуу, түүгээр ч үл барам гал тогооны хэрэгсэл, гар хадуур, анжис, шимээсэг, тармуур, хүрз, зээтүү, жоотуу зэрэг хөдөө аж ахуйн багаж хэрэгслийг цөм нийгэмчилсэн юм. Тэгээд коммуны гишүүдийг нийтээрээ нэг гал тогооноос үнэгүй хооллох систем тогтоож, үүнийг маогийнхан хятадад өлсгөлөн хүн байхгүй болсон мэтээр сурталчилж байв. Гэтэл бодит байдал тэс ондоо болж, коммунуудад тариачдыг 3 сар үнэгүйгээр хооллоход Хятадын үр тарианы бүх нөөц дуусч, тариалангийн талбайд хэрэглэх үрээ аргагүй идэхэд хүрсэн юм. Өөрөөр хэлбэл үнэгүй хооллолт маань тариачдад ямар ч мөнгөн орлогогүй хоёр нарны хооронд амралтын адэргүй ажилладаг өлсгөлөнгийн норм болж хувирчээ.

Мао Зэдүний бүлэг улс орныхоо хөгжлийг түргэтгэх, хоцрогдлыг арилгах, социализм байгуулах гэсэн Хятадын коммунистууд, хөдөлмөрчдийн чин эрмэлзлэлийг өөрсдийнхөө үндсэрхэг зорилгод хортойгоор ашигласан нь орон даяар, юуны өмнө намын идэвхтний дотор гүн дургүйцлийг хүргэсэн юм. Маогийн улс төрийн энэ буруу бодлогыг ХКН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны гишүүн, БНХАУ-ын Батлан хамгаалах яамны

сайд байсан Пэн Дэхуай, Намын төв хорооны улс төрийн товчооны орлогч гишүүн, Гадаад явдлын яамны орлогч сайд байсан Жан Вэньтянь, Хятадын Ардын Чөлөөлөх Армийн жанжин штабын дарга байсан Хуан Кэчэн, Хунань мужийн намын хорооны 1-р нарийн бичгийн дарга байсан Жоу Сяожоу нар эсэргүүцэн, 1959 оны зун Лушанд хуралдсан ХКН-ын Төв Хорооны бүгд хурал дээр эрс шүүмжилж, түүнийг засаж залруулах арга хэмжээ яаралтай авахыг шаарджээ. Мао Зэдүн, түүний талынхан сөрөг бүлгийнхнийгээ хагалан бутаргаж, айлган сүрдүүлэх арга мэх хэрэглэсний эцэст Пэн Дэхуай болон түүний талынхныг «баруунтнууд» гэж зарлан, албан тушаалаас нь зайлуулж, тэдэнд хатуу ширүүн эрүү шүүлт тулгасан юм. Тэр Лушаны бүгд хурлын дараагаар «барууны хэлбэрлийн» эсрэг тэмцэх нэрийдлээр намын дотор өргөн цэвэрлэгээ хийж, өөрийн нь бодлогод дургүйцсэн хүмүүсийг мөрдөн шүүж, үй олон хүнийг «хөдөлмөрөөр дахин хүмүүжүүлэхээр» тосгонд явуулж цөлжээ.

Мао Зэдүний «3 улаан тугийн» бодлого нь марксизм-ленинизмийн онол, ЗХУ болон социализмын бусад орны социалист байгуулалтын практикт эрс харш зүйл байв. БНХАУ-д уригдан ажиллаж байсаы зөвлөлтийн мэргэжилтнүүдэд техникийн норм хэмжээ, хүчин чадлаас хальсан хэт давуу зүйл хийхийг маогийнхан «их үсрэлтийн» жилүүдэд шаардаж, тэднийг цаашид ажиллах бололцоогүй болгосон учир ЗХУ 1960 оны зун БНХАУ-аас мэргэжилтнүүдээ татаж авсан юм.

«3 улаан тугийн» бодлого БНХАУ-ын нийгэм-эдийн засаг, улс төрийн байдлыг гүн гүнзгий хямралд оруулсан билээ. Юуны өмнө улс ардын аж ахуйн хөгжлийн тэнцвэр ноцтой зөрчигдөж, үндэсний ба улсын төсвийн орлого эрс буурч, орон даяар өлсгөлөн болж, ажилчид, сэхээтэн, ялангуяа тариачдын дунд дургүйцэл маш хүчтэй болов. Армийн дотор ч дургүйцэл бас ихэсчээ. Хятадын дотоод улс төрийн тэмцэл хурцдахын зэрэгцээ олон улсын тавцан дээр Хятад Ард Улсын байр суурь бас муудаж эхэлжээ. Өөрөөр хэлбэл, маоизмын гүнзгий хямрал эхэлж, Маогийн нэр хүнд Хятадад болон дэлхий дахинд унаж эхэлсэн юм.

Ийм нөхцөл байдлыг харгалзан, Хятадын удирдлага 60-аад оны эхэн үеэс эхлэн улс ардын аж ахуйн хөгжлийг «зохицуулах» бодлого явуулах болж, «их үсрэлтийн» хор уршгийг арилгах арга хэмжээ боловсруулжээ. Энэ бодлогын гол нь хөдөө аж ахуйг бэхжүүлэхэд чиглэгджээ. Энэ нь «хөдөө аж ахуйг улс ардын аж ахуйн үндэс, аж үйлдвэрийн гол хүч» гэж томъёолсноос тодорхой байна. Энэ «зохицуулалтын» бодлогоор эдийн засгийн нилээд арга хэмжээ авсаны дотор ардын коммунуудыг зарим талаар өөрчлөн байгуулж, их барилгын ажлыг эрс багасгаж, жижиг болхи үйлдвэрийн газруудыг олноор байгуулах явдлыг зогсоож, үйлдвэр, барилгын зарим газрыг хаах буюу барьж байгуулахыг хойшлуулж, үйлдвэрийн нилээд олон газраар үйлдвэрийн тоног төхөөрөмж үйлдвэрлэн гаргадгийг хөдөө аж ахуйн багаж хэрэгсэл болон гэр ахуйн хэрэгсэл үйлдвэрлэдэг болгосон зэрэг арга хэмжээ авчээ. 1961—1962 онд засаг захиргааны аргаар хотоос 20 сая гаруй хүнийг хөдөө тосгонд явуулж ажиллуулсан нь ажилчин ангийг тооны хувьд эрс бууруулав. Бүтээгдэхүүний чанар, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд зарим үед хийснээр нь хөлс олгох журмыг сэргээж, тариачдад өөрсдийн хэсэг газар, амины гахай, тэжээмэл шувуутай байхыг зөвшөөрч, гэр ахуйн хэрэгслийг нь эгүүлэн олгожээ.

Эдгээр арга хэмжээ нь улс орны үйлдвэрлэлийн уналтыг зөвхөн зогсоосноос биш нийт улс ардын аж ахуйг өөд татаж чадаагүй юм. Бэрхшээл, цэвэрлэгээ, залхаан цээрлүүлэлт үргэлжилсэн хэвээр байв.

Энэ үед маогийн бүлгээс явуулж байсан бодлогод намын гишүүд, олон түмний дотор дургүйцэл бас л хүчтэй гарч, Мао Зэдүний «үзэл санаа», бодлогыг төв, орон нутагт илэрхий биш ч гэсэн, далдуур шүүмж-

лэх явдал ихэсч байсныг хятадын нэрт эдийн засагч Сунь Ефан, зохиолч Шао Цюаньлинь, Бээжин хотын ардын хорооны орлогч дарга байсан нэрт зохиолч, түүхч У Хань, мөн хотын намын хорооны нарийн бичгийн дарга байсан Дэн То, Ляо Моша нар хэвлэлд битүүгээр шүүмжилж бичсэн зүйл тод гэрчилж байна. Мөн энэ үед ХКН-ын Төв Хорооны орлогч дарга, БНХАУ-ын дарга байсан Лю Шаоци хэлсэн зарим үгэндээ «их үсрэлтийн» бодлогыг шүүмжилж, «их үсрэлтээс» өмнөх ХКН-ын бодлого нь Маркс, Лениний заалтуудад тулгуурлаж байсан бөгөөд «их үсрэлтийн» чиг шугам нь Мао Зэдүний нэртэй шууд холбоотой юм гэж дурдан, бэрхшээлийн ихэнх нь «алдаа завхарлаас болсон юм»¹ гэжээ.

Мао Зэдүний бүлгээс явуулж байсан бодлогод дургүйцэх хандлага орон даяар цухалзаж, түүнийг шүүмжлэх явдал намын байгууллагуудыг хамран, улс орны эдийн засаг хямралын байдлаас гарч чадахгүй, харин ч доройтож байсан нь Хятадын дотоод улс төрийн байдлыг улам хүндрүүлэв. 60-аад оны дунд үе гэхэд хятадын нам, төрийн удирдлагад Мао Зэдүний бүлэг, Лю Шаоцигийн талынхны хооронд улс орны дотоод, гадаад бодлогын гол зангилаа асуудлаар тэмцэл эрс хурцадсан юм. Мао Зэдүний бүлэг дэлхий дахинд Хятадын жанжлалыг тогтоох зорилгыг биелүүлэхийн тулд түүнийг цэргийн хүчирхэг гүрэн болгох бодлогын чиг шугамаа баримталж, харин Лю Шаоци, түүний талынхан Хятадын хөгжлийн хурдцыг дэвшилттэй байхаас гадна «манлайлах үзлийн» үүднээс биш, Хятадын бодит байдлыг харгалзан үзэж, хөдөлмөрчин олон түмэнд хэт хүнд дарамт бий болгохгүй байх, эдийн засгийн хөгжлийн зөв тэнцвэрийг барьж ажиллах талаар тогтвортой бөгөөд найдвартай байх ёстой гэж үзэж байв.

Гадаад бодлогын хувьд Мао Зэдүний бүлэг «3 улаан тугийн» бодлогыг зарласан цагаас эхлэн адал балмад чиг шугамаа нэн хүчтэй болгож, дэлхийн социализмыг империализмтэй мөргөлдүүлэхэд чиглэсэн явууллагыг өөрөө өдөөн хатгах буюу бусдыг турхирах замаар хийх болсон юм. Үүний тод нотолгоо бол Хятадын удирдлага 1958 онд Тайваний хоолойд өдөөн хатгалга хийж, АНУ-аас БНХАУ болон дэлхийн социализмын эсрэг атомын дайн хийх аюулд оруулан, 1959 онд Энэтхэгийн эсрэг хилийн зэвсэгт будлиан үүсгэж, 1962 онд Карибын тэнгисийн районд бий болсон олон улсын хурц хямралын үеэр ЗХУ, АНУ-ыг мөргөлдүүлэх илэрхий өдөөн хатгасан бодлогын чиг шугам баримталж, 1965 оноос америкийн империализмаас вьетнамын ард түмний эсрэг зэвсэгт түрэмгийлэл эхлэн явуулсан цуст дайны жилүүдэд БНАВУ-д тусалж байгаа дүр үзүүлэн үнэн хэрэгтээ АНУ-ын түрэмгийллийг өөгшүүлж, Вьетнамыг өөрийн эрхшээлд авах гэсэн өөдгүй үндсэрхэг бодлого явуулж байсан явдал мөн. 1960 оны хавраас эхлэн Мао Зэдүний бүлэг орчин үеийг тодорхойлох, дайн ба энх тайвны асуудал, янз бүрийн улс орон социализмд шилжин орох хэлбэрийн тухай, нэг хүнийг тахин шүтэхийн хор уршгийг гэтлэн давах зэрэг олон улсын коммунист хөдөлгөөний онол практик, стратеги тактикийн чухал асуудлаар баримталж байсан гаж буруу чиг шугамаа ах дүү социалист орнууд болон коммунист, ажилчны намуудад тулган хүлээлгэхийг эрмэлзэн, 1963 оны 6-р сард «Олон улсын коммунист хөдөлгөөний жанжин шугамын тухай санал» гэгчийг илт гарган тавьж, хагалан бутаргах явууллагаа илэрхий үйлдэх болсон юм.

Энэ үеэс эхлэн Хятадын Коммунист Намын удирдлага олон улсын коммунист хөдөлгөөний марксч-ленинч отрядиудаас үзэл суртал, зохион байгуулалтын талаар ангижран салж, БНХАУ-ыг социалист орнуудаас алхам алхмаар холдуулан, империалист улсуудтай улам бүр ойртуулах болсон юм. Маогийнхан коммунист хөдөлгөөний отрядиудад хагарал гар-

¹ Журнал «Проблемы Дальнего Востока», 1979, № 3, 16-р тал.

гагч бүлгүүдийг бий болгон дэмжиж, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг эрхшээлдээ оруулах оролдлого хийж», «Азийг азийнхан», «Африкийг африкийнхан» гэдэг арьсны үзэлт бодлогын зарчим дэвшүүлж байснаас гадна Хятадыг империализм, «ревизионизм» тойрон бүслээд байгаа мэтээр дүрслэн ярьсан суртал нэвтрүүлэг дэгдээж байв.

Мао Зэдүний бүлгийн дээрх бодлогын зарим зүйлийг ХКН-ын удирдлагын Лю Шаоци тэргүүтэй хэсэг эсэргүүцэж, ялангуяа Вьетнамд үйлдэж байсан америкийн түрэмгийллийн эсрэг тэмцэх талаар ЗХУ болон социалист бусад орон, коммунист намуудтай үйл ажиллагаагаа нэгдмэл болгохыг шаардаж байжээ.

Мао Зэдүн сөрөг хүчнийхээ эсрэг армийг идэвхтэй бэлтгэж, намын удирдах ролийг үгүйсгэн, нам, төрийн дотор өөрийгөө тахин шүтүүлэх ажил зохиож «Армиас суралцагтун!», «Арми бол удирдан чиглүүлэх хүч мөн» гэдэг лоозон дэвшүүлэн, армийн ролийг хэт өргөн тавьж байв.

Намын дотор сөрөг хүмүүсийг хуралдаж бөөгнөрөхөөс айж болгоомжилсон Мао Зэдүн, түүний талынхан «Пролетарийн соёлын их хувьсгал» гэдэг нэрийдлээр орон даяар хувьсгалын эсэргүү улс төрийн эргэлт хийсэн юм. Уг эргэлтээр Маог эсэргүүцсэн улс төрийн дайснуудыг зайлуулж, ардын ардчилсан системийг тэс ондоо болгон өөрчилж, цэрэг- хүнд суртлын диктатурыг тогтоов. Энэ диктатур нь Маогийн улс төрийн чиг шугамыг бататгаж, Хятадыг цэрэгжсэн гүрэн болгох арга замыг ханган, их гүрний жанжлах гадаад бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл болсон юм. Мао Зэдүн өөрөө гардан удирдаж хийсэн «соёлын хувьсгалын» явцад нам, армийн нэрт зүтгэлтнүүд, олон тооны кадр ажилтан хэлмэгдэж, ХКН-ын Төв Хорооны гишүүдийн зонхилох олонхийг зайлуулан, муж, хот, хошуудын намын хороодыг устгаж, иргэний ба намын бүх байгууллагын үйл ажиллагааг зогсоож, төрийн байгууллагууд болон үйлдвэрчин, залуучууд, эмэгтэйчүүд зэрэг олон нийтийн бүх байгууллагыг тараажээ. Мао Зэдүн сөрөг хүчнээ хайр найргүй хатуу ширүүн дарж устган, тэдний эсрэг болон хүн амын эсрэг аллага таллагын өргөн кампанит ажил өрнүүлж, хэдэн арван сая хүний амь насыг бүрэлгэсэн юм.

«Соёлын хувьсгал» улс орны эдийн засгийг удирдах системийг бусниулж, БНХАУ-ын төрийн зөвлөл, яамд, тусгай газруудын үйл ажиллагааг ихээхэн хэмжээгээр тасалдуулан, нийт улс ардын аж ахуй, ялангуяа аж үйлдвэр, тээврийн салбарт нэн хүнд бэрхшээл учруулав. Нам, төр, олон нийтийн байгууллагуудын халааг авсан цэрэг-хүнд суртлын диктатурын байгууллага болох «хувьсгалт хороод» үйлдвэрлэл хуваарилалтанд цэргийн аргаар хяналт тавихдаа уг ажлыг үр ашигтай хийж чадахгүй байлаа. Хөдөлмөрийг албадлагын хэлбэрээр зохион байгуулж, хөдөлмөрчдийн аж амьдралыг улам ядуу дорой болгосон нь тэдний хөдөлмөрлөх идэвхийг эрс бууруулснаас гадна улс орныг цэрэгжүүлэх ажлыг эрс түргэтгэн явуулж, материаллаг нөөцийн ихээхэн хэсгийг цэргийн үйлдвэрийн чадавхийг өсгөн нэмэгдүүлэхэд зориулсанаас Хятадын нийт хөгжил саатаж, олон зуун сая хүн амыг хүнсний болон аж үйлдвэрийн өргөн хэрэгцээний бараа таваараар хангах явдал эрс буурчээ. «Соёлын хувьсгалаас» болж, БНХАУ-ын улс ардын аж ахуйд шаардлагатай байсан мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх явдал тасалдсан бөгөөд эрдэмтэд, инженер-техникчид, дунд, доод шатны кадр ажилтны ихэнх нь хэлмэгдэж бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах ажил зогсож, сургуулийн насны хүүхдүүдийн зонхилох ихэнх нь сурах бололцоогүй болжээ.

«Соёлын хувьсгалын» үр дүнд бий болсон Хятадын одоогийн милитаризм нь улс орныг цэргийн албадлага, хүчирхийллийн аргаар захирч, олон улсын тавцан дээр Хятадын их гүрний жанжлах санаархлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий харгис систем болж байна.

1969 оны 4-р сард хуралдсан ХКН-ын IX их хурал «Соёлын хувьсгалаар» буй болсон улс төрийн эргэлтийг албан ёсоор бататган дэлхий дахины хэмжээгээр социалист хувьсгал ялахаас нааш социализм байгуулах боломжгүй тухай «тасралтгүй хувьсгал» хийх троцкист онолд тулгуурлан Хятадад социализм байгуулах тухай асуудлыг үнэн хэрэгтээ хойш тавьсан юм. Их хурал зөвлөлтийн эсрэг үзлийг БНХАУ-ын төрийн гадаад бодлогын хэмжээнд өргөн дээшүүлж, үзэл суртал, зохион байгуулалтын зарчим, бүхий л бодлогоороо марксизм-ленинизмд харш маогийн шинэ намыг ХКН гэдэг нэрээр өөрчлөн зохион байгуулсан хурал болжээ.

Хятадын ардын хувьсгалын ялалтын үр дүнд бий болсон улс төрийн системийг эвдэн бусниулсан нь аж ахуйг социалист ёсоор эрхлэх зарчим, эдийн засгийн хуулийг ноцтой зөрчиж, социалист эдийн засгийн суурийг өөрчлөн хятадын хөдөлмөрчдийн социалист ололтыг аюулд оруулав. Хятадын удирдлагын доторхи үндсэрхэг бүлгүүдийн хооронд цэрэг- хүнд суртлын дэглэмийг бататгах, түүний улс төрийн системийг буй болгох, нийгэм-эдийн засгийн хөгжлийн чиглэлийг тогтоох, боловсон хүчнийг шилж сонгон хуваарилах, гадаад улс төрийн бодлогын чиг баримжааг тодорхойлох зэрэг асуудлаар засгийн эрхийн төлөө тэмцэл хурцдан, улс орны байдал тогтворгүй болж байв.

70-аад оны эхэн үеэр Мао Зэдүний бүлэг улс орон нь техник-эдийн засгийн талаар үлэмж их хоцорч, БНХАУ гадаад ертөнцөөс тасарч ганцаардан, «өөрийн хүчинд тулгуурлах» бодлого үр дүнгүй болсон зэрэг байдлыг цэгнэн үзэхгүй байж чадаагүй юм. Хятадын удирдлагад империалист том гүрнүүд, юуны өмнө АНУ-тай ойртох хандлага зонхилж, БНХАУ-ын хөгжлийг түргэтгэхэд капитализмын өндөр хөгжилтэй орнуудын эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн чадавхийг ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орны эсрэг тэмцэлдээ ашиглах гэсэн Мао Зэдүн, Жоу Энълай нарын эрмэлзлэл хүчтэй болж ирэв.

Мао Зэдүний бүлэг империалист хамгийн харгис хүчинтэй ойртон эвсэл холбоо байгуулж, юуны өмнө АНУ-тай нягт харилцаа тогтоохыг эрмэлзэн, ЗХУ-ыг нэгдүгээр зэргийн дайснаа гэж үзсэн Мао-Жоу нарын бодлого нь Хятадын удирдагчдын дотор, тухайлбал Мао Зэдүнд хамгийн ойр байсан хүмүүсийн ч дургүйцлийг хүргэжээ. Ялангуяа Хятадын Ардын Чөлөөлөх Армийн дээд командлалын дотор Мао Зэдүний дээрх бодлогыг эсэргүүцсэн хүч илэрч, 1971 оны 9-р сард «Линь Бяогийн хэрэг» гэгч гарсан юм. Энэ «хэрэг» гэгчтэй холбогдуулан маогийн бүлэг аллага, таллагын шинэ кампанит ажил өрнүүлж, нам, армийн удирдах бүрэлдэхүүнийг өөрчилсөн юм.

Улс орны байдлыг тогтворжуулах зорилгоор 1973 оны 8-р сард нууц байдалд ХКН-ын X их хурал хуралдаж, Хятадын удирдлагын дотоод гадаад бодлогын талаар үндсэндээ түрүүчийн их хурлаас тодорхойлсон чиг шугамыг батлан, «соёлын хувьсгалыг» өргөмжлөн магтах тугийн дор болж өнгөрөв. Тус их хурал Хятадын нийгэм-эдийн засаг, соёлын чухал асуудлын талаар чимээгүй өнгөрч, «3 улаан тугийн» бодлогоос хойшхи хугацаанд Мао Зэдүнгээс өгч байсан гол заалтуудыг дахин давтаж, «зайлшгүй дайнд заавал бэлтгэе!» гэсэн лоозон дэвшүүлэв. Мөн их хурлаас баталсан намын дүрэмд Мао Зэдүний «үзэл санааг» ХКН-ын онолын үндэс гэж мөнхжүүлэх, маогийн улс төрийн бодлогын гол зүйлүүдийг намын программын удаан хугацааны заалтууд болгон бататгах оролдлого хийсэн юм. Их хурлын дараагаар «Линь Бяо ба Күнзийг шүүмжлэх нь» гэсэн улсын хэмжээний улс төр-үзэл суртлын кампанит ажил зохиосон нь маогийн нэгэнт тогтсон дэглэмийн хүрээнд явагдсан бас нэг «соёлын хувьсгал» байв. Энэ кампанит ажлыг явуулахдаа өрхийн цэргийн отрядуудыг олноор байгуулж, өргөн олон ажилчин, тариачин, цэрэг, оюутны хурал цуглааныг зохион, «соёлын хувьсгалыг» хамгаалах, нийгмийн «дав-

харгад хувьсгалыг» үргэлжлүүлэх шаардлага тавиулж байв. Линь Бяо ба Күнзийг шүүмжилсэн кампанит ажлын цаана нэгэнт тогтсон дэглэмийг бататгах, түүний улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх, маоизмыг нийгмийн гишүүдийн ухамсарт бүх талаар шингээхийн төлөө нам, арми, төрийн аппаратад «Линь Бяо ба Күнзийг талархагч» бүх хүмүүсийн эсрэг маоист удирдлагаас хийх улс төр-үзэл суртлын тэмцлийн чухал асуудлууд нуугдаж байв. Энэ кампанит ажлыг явуулснаар Цзян Цины бүлэг Мао Зэдүнийг амьд байхад нам, төрийн аппарат, армийн дунд ноёлох байр суурьтай болох юм гэж тооцоолжээ. Энэ нь Мао Зэдүний санаанд тохирч байжээ. Учир нь энэ бүлгийнхэн Маог нас барсны дараа түүний «үзэл санаа», заалтыг үнэнчээр хэрэгжүүлж чадна гэж Мао Зэдүн өөрөө ч үзэж байв. Маод хамгийн үнэнч Цзян Цины бүлэг байр сууриа улс орны дээд удирдлагын дотор бэхжүүлэх зорилгоор мөн энэ үед «Пролетарийн диктатурын онолыг судлах» зэрэг улс төрийн бусад кампанит ажил өрнүүлж байв. Тэгэхдээ энэ бүх кампанит ажил нь засгийн эрхийн төлөө янз бүрийн маоист бүлгийн хооронд тэмцэл маш их хурцадсаны шинж тэмдэг болж байв. Улс орны дотоодод болон олон улсын тавцан дээр 1974 оны хавраас эхлэн маогийнхан пролетарийн ангич бодлогод эрс харш «гурван ертөнцийн тухай» онол гэгчийг хөөргөн дэвэргэсэн юм.

1976 оны 9-р сарын 9-нд Мао Зэдүнийг нас барах үед БНХАУ-ын улс төрийн байдал тогтворгүй, нийт хөгжлийн хэмжээ дорой хэвээр үлдсэн юм. Цэрэгжилтийн дааж давшгүй зардал төсөвт шавхагдсанаас болж хөдөлмөрчин ард түмний аж амьдралын хэмжээ эрс доройтон, БНХАУ-ын улс ардын аж ахуйн хөгжил «их үсрэлтийн» өмнөх үеэс 10—15 жилээр хойш татагджээ. Маоизм онол, практикийн хувьд гүнзгий хямралд орж, «залуурчийн» их хан үндэстний стратегийн санаархлыг хэрэгжүүлэх явдал бүтэхгүй болох нь тодорхой байв.

Хятадын маоист удирдлагын дотор маоизмын стратегийн зорилтыг хэрэгжүүлэх, улс орныг удирдах, хөгжүүлэх арга барилын асуудлаар засгийн эрхийн төлөө зөрчил тэмцэл маш хурцдав. Юуны өмнө нам, төрийн удирдлагаас Мао Зэдүнд хамгийн ойр дотно байсан Цзян Цин, Ван Хун-вэнь, Чжан Чуньцяо, Яо Вэньюань нарын бүлгийг зайлуулж, тэднийг «дөрвөн дээрэмчин» гэж хараан, улс орон даяар бий болсон хямралын байдал, «соёлын хувьсгалын» үеэр явагдсан харгислал, аллага, таллагын бүх бурууг тэдэнд тохжээ.

Маог залгамжлан авсан Хуа Гофэн тэргүүтэй одоогийн удирдлага хятадын их гүрний дээрэнгүй жанжлах маоист бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор дотоод бодлогын хувьд аж үйлдвэр, хөдөө аж ахуй, арми, шинжлэх ухаан-техник гэдэг «дөрвөн шинэчлэлтийн» бодлого явуулж байна. Маог залгамжлагчид дотоод бодлогын талаар Мао Зэдүний улигт олон заалтаас аман дээрээ биш ч гэсэн үнэн хэрэгтээ зарим талаар ухарч, маоизмын үр ашгаа өгөхөө больсон онол, практикт зарим засварыг хийж байгаа боловч Хятадыг цэрэг-эдийн засгийн талаар дэлхийн тэргүүний улс болгон хувиргах Хятадын жанжлалыг дэлхий дахинд тогтоох зорилтыг хэрэгжүүлэхээс өчүүхэн ч татгалзаагүйгээр үл барам, харин ч түүнийг биелүүлэх талаар бүхнийг хийж байна.

1977 оны 8-р сард хуралдсан ХКН-ын XI их хурал, 1978 оны хавар, мөн 1979 оны зун хуралдсан БХАТХ-ын чуулгануудын шийдвэр нь хятадын одоогийн удирдагчид их хан үндэстний дээрэнгүй жанжлах маоист бодлогын чиг шугамд үнэнч байгааг ний нуугүй харуулав.

Хятадын одоогийн удирдлага «4 шинэчлэлтийг» улс ардын аж ахуйн хэрэгцээ, хүн амын аж амьдралыг дээшлүүлэхэд зориулахгүй, харин түүний гол агуулгыг цэрэг-аж үйлдвэрийн томоохон баазыг буй болгоход чиглүүлж, БНХАУ-ыг цэргийн хүчирхэг гүрэн болгон хувиргах Мао Зэ-

дүний хуучин бодлогыг үргэлжлүүлэхэд чиглүүлж байна. Энэ зорилтыг шийдвэрлэхэд Хятадын удирдагчид гол хөрөнгөтөн орнуудын капиталыг татан оруулж, тэдгээрийн шинжлэх ухаан-техникийн ололтыг авч ашиглахыг эрмэлзэж байна. Империалист улсуудын амлаж байгаа олон миллиард валютын зээлийг БНХАУ-ын засгийн газар цэргийн үйлдвэрээ сэлбэж шинэчлэх, армия орчин үеийн зэвсэг техникээр зэвсэглэхэд зориулж байгаа нь Хятадын хомс нөөцийг үгүйрүүлэн, түүний эдийн засгийн нийт хөгжлийг саатуулж, Хятадыг гадаадын ховдог шунахай капиталын хараат байдалд оруулж байна.

Дэлхий дахинд Хятадын жанжлалыг хангах зорилгоор БНХАУ-ыг энэ зууны эцэс гэхэд дэлхийд «аж үйлдвэрийн тэргүүний гүрэн» болгох талаар бээжингийн одоогийн удирдагчдын тавьж буй санаархал нь биелэх үндэсгүй юм. Хятад улс эдийн засгийн хувьд дэлхийн аж үйлдвэрийн тэргүүний хөгжилтэй орнуудаас хол хоцорсон хэвээр байна. Одоо БНХАУ дэлхийн нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний дөнгөж 4 хувийг гаргаж байхад ЗХУ 20 гаруй хувийг үйлдвэрлэж байна. Хүнд аж үйлдвэрийн чухал үзүүлэлт болох ган хайлуулалтаар БНХАУ Японоос 3 дахин, АНУ-аас 4 дахин, ЗХУ-аас 5 дахин бага, нефть, цахилгаан эрчим хүч гаргалтаар ЗХУ-аас 5—6 дахин бага байна. Зөвхөн эдгээр баримтаас үзсэн ч энэ зууны эцэс гэхэд БНХАУ хичнээн түргэн хурдацтайгаар хөгжлөө ч гэсэн дэлхийн аж үйлдвэрийн хамгийн тэргүүний орон болж чадахгүй нь мэдээж байна.

Өрнөдийн империалист гүрнүүд болон Японы капиталын туслалцаатайгаар Хятадыг цэргийн «хэт аж үйлдвэржсэн» улс болгох гэж бээжингийн удирдагчид санаархаж буй нь Хятадыг империализмын дэлхий дахины стратегийн зэвсэг болгон ашиглах, БНХАУ байгуулагдсаны дараах эхний 10 шахам жилд олсон хятадын ард түмний социалист ололтыг бүрмөсөн үрэн таран болгож байгаа аюултай алхам мөн.

Хэдийгээр БНХАУ байгуулагдсанаас хойш өнгөрсөн хугацаанд түүний материаллаг үйлдвэрлэл зохих хэмжээгээр нэмэгдсэн ч гэсэн сүүлийн 20 гаруй жилд хятадын хөдөлмөрчдийн аж амьдралын түвшин огтхон ч дээшилсэнгүй. Үүний учир бол Хятадын маоист удирдагчдаас улс орныг цэрэгжүүлэх бодлого явуулан, хөдөлмөрчин ард түмний эдийн засгийн ашиг сонирхлыг хайхарч үзээгүйд оршино. Үүнээс болж хятадын олон зуун сая хүний аж амьдрал хохирч тэсвэрлэшгүй хүнд байдалтай байна. Одоо хятадад хоол хүнсний зүйл, хувцас хунар маш хүрэлцээгүй ховор хомс байгаа учраас тэдгээрийг тогтоосон хатуу нормоор, өл залгах төдий хэмжээгээр олгосон хэвээр байгаагаас гадна цэрэг дайны бэлтгэлээ хангахад хөрөнгө мөнгө олох зорилгоор 1979 оны намар Хятадад хүнсний болон аж үйлдвэрийн олон нэр төрлийн барааны үнийг нэмэгдүүллээ. Үүний зэрэгцээ хөдөлмөрчид эмнэлэгт үзүүлж эмчлүүлэх, сургуульд хүүхдээ суралцуулах явдал цөм үнэтэй байгаагийн дээр хятадын, ялангуяа хот суурин газрын нэг гэр бүл 2-оос илүү хүүхэдтэй байж болохгүй бөгөөд хэрэв энэ тогтоосон нормыг зөрчиж төрүүлсэн илүү хүүхдүүдэд хоол хүнс, бөс бараа хувцасны нормын талон олгодоггүй ба орон сууц хуваарлахад ч тэднийг хүн гэж үзэж талбай оногдуулдаггүй байна. Мөн Хятадын удирдлага эрэгтэй, эмэгтэй залуу хүмүүсийн үр устгах ажлыг өргөн явуулж, залуу гэр бүлийн эхнэр, нөхрийг хамт амьдруулахгүй, энд тэнд олон жилээр албан журмын хөдөлмөрт ажиллуулж байгаа зэрэг хүний энэрэнгүй ёсноос гадуур ажил хийсэн хэвээр байна.

Өнөөгийн Хятадын нийгэм-эдийн засгийн хөгжлийн хамгийн гол шинж нь улс орныг бүх талаар цэрэгжүүлэн, улсын төсвийн бараг тэн хагасыг цэрэг, дайны бэлтгэлд зориулж, аж ахуйг цэрэг-хуарангийн аргаар эрхлэх явдлыг өргөн дэлгэрүүлэн албан журмын хөдөлмөрт хүмүүсийг дайчлан оруулж, харгислал, аллага, таллагын бүхий л хэлбэрийг улам

ширүүсгэж байгаагаар тодорхойлогдож байна. Одоо Хятадад хэдийгээр маоист удирдах бүлгүүдийн хооронд эрх тушаалын төлөө зөрчил байгаа ч гэсэн гол тэмцэл нь удирдлага, олон түмний хооронд явагдаж байна. «Соёлын хувьсгалд» хууртагдаж өртөгдсөн буюу хэлмэгдсэн, гомдсон 100 сая гаруй хүн ямар нэг хэмжээгээр Хятадын одоогийн удирдлагад дургүй байгаагийн дээр Хятадын удирдах хүмүүсийн хэлснээс үзэхэд Хятадад хагас өлсгөлөнгийн байдалд 100 сая гаруй хүн, ажилгүй 20 сая гаруй хүн байна. Хятадын хэвлэл, мэдээллийн газар зэрэг олон түмний мэдээллийн хэрэгсэл мэдээлэхгүй байгаа болохоос биш, үнэндээ одоо Хятадад «Линь Бяо ба дөрвөн дээрэмчний» хор уршгийг арилгах, «улс орон даяар хэв журам тогтоох» гэдэг нэрийдлээр «соёлын хувьсгалын» үеийнхээс хаа хамаагүй олон хүний амь насыг бүрэлгэж байна. Орон даяар тогтсон цэрэг- хүнд суртлын дэглэмд арми бас л олон талтай үүрэг гүйцэтгэж байна. Ялангуяа БНХАУ -ын хөдөө тосгоны тариачдын амьдрал туйлын ядуу дорой байна. Хятадын нэг тариачны жилийн мөнгөн орлого хотын нэг ажилчин буюу албан хаагчийн нэг сарын цалинтай тэнцэж байгаа нь хөдөө тосгон хүн амаар хэт дүүрсэнтэй холбоотой юм. Одоо Хятадын хөдөө тосгоны 800 сая гаруй тариачдын дөнгөж 300 сая гаруй нь материаллаг үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

Хятадын одоогийн маоист удирдагчид БНХАУ-ын үндэсний районуудын хувьд ч гэсэн их хан үндэстний дээрэнгүй бодлогыг шургуу хэрэгжүүлж, төрөл бүрийн аргаар хятад биш үндэстнийг хайлуулж уусган тэдгээрийн газар нутаг, хүн ам, бүх нөөц баялгийг бусад орны эсрэг бэлтгэж байгаа дайн түрэмгийллийн хэрэгцээнд зориулж байна.

Хувьсгал, социализмын үйл хэргээс урван тэрсэлж харгис маоизмыг удирдлага болгосон бээжингийн эрх баригчид «соёлын хувьсгалаас» хойш ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орныг дайсагнасан гадаад бодлогын чиг шугамаа улам ширүүсгэж, социализмын ах дүү улсуудтай харилцаагаа эрс муутган, 1969 онд Зөвлөлт-Хятадын хил дээр ээвсэгт өдөөн хатгалгыг нэг биш удаа гаргасан юм. Маогийнхнаас ЗХУ-ын эсрэг үйлдсэн хилийн зэвсэгт өдөөн хатгалгаа, мөн ЗХУ-ыг Хятадын гол дайсан гэж албан ёсоор зарласан явдал империалист харгис хүчинд туйлын их таалагдсан учир зөвлөлтийг болон социализмыг дайсагнасан бээжингийнхний бодлогыг тэд зүйл бүрээр дэмжиж, Хятадтай аль болохоор ойртон, нягт харилцаа холбоо тогтоон хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Энэ нь 1971 онд Хятад-Америкийн хооронд анхны албан ёсны харилцаа тогтож, ЗХУ-ыг хамтран эсэргүүцэх, Ази ба Номхон далайн сав газарт нөлөөнийхөө хүрээг АНУ, Хятад хоёр хуваарилан тогтоох үндсэн чиглэлийг заасан 1972 оны Шанхайн албан мэдээнд тод тусгалаа олсон юм. Чухамхүү энэ үеэс эхлэн БНХАУ империалист гүрнүүдтэй худалдаа, эдийн засаг, цэргийн харилцааг өргөтгөн хөгжүүлж байна.

БНХАУ-аас империалист улсуудтай өргөжүүлэн хөгжүүлж байгаа харилцаа нь олон улсын намжмал байдлын үйл явцыг тасалдуулж дэлхий дахиныг «хүйтэн дайны» байдалд эгүүлэн оруулах, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн бусад орны эсрэг дайн түрэмгийллийг яаравчлан бэлтгэх, үүний тулд юуны өмнө империалист улсуудын пуужин-цөмийн зэвсгийн нууцыг олж авч Хятадын армийг орчин үеийн зэвсэг техникээр зэвсэглэхэд чиглэж байгаа юм.

Хятадын удирдлага Октябрийн хувьсгал, ленинизмийн эх орон-ЗХУ-ыг «социал-империализм» болж хувирсан, «социалист лагерь гэж байхаа больсон» мэтээр зарлаж, ЗХУ болон социалист хамтын нөхөрлөлийн эсрэг «дэлхий дахины өргөн фронт» байгуулахыг шууд уриалсан хорт явууллагаа үйлдсээр байна. Бээжингийн суртал нэвтрүүлэг ЗХУ болон дэлхийн социализм, олон улсын коммунист, ажилчны болон үндэсний эрх чө-

лөөний хөдөлгөөн, дэлхийн бүх дэвшилт хүчнийг гүтгэн дайрч хараан зүхэх талаар коммунизмын эсрэг империалист харгис суртал нэвтрүүлэгтэй дуу хоолойгоо хослон нийлүүлж байгаагаар барахгүй намжмал байдлын үйл явцыг эсэргүүцэх, олон улсын байдлыг түгшүүртэй болгох, дайн түрэмгийллийг өөгшүүлж хөөргөн дэвэргэх явууллагаараа зарим үед түүнээс хол давж байгаа юм.

Мао Зэдүний халааг авсан Хуа Гофэн тэргүүтэй бээжингийн одоогийн удирдлага өргөн олон түмний хүсэл эрмэлзлэл шаардлагыг биелүүлж байгаа дүр үзүүлэн, ХКН-ын VIII их хурлын шийдвэрийг хэрэгжүүлж байгаа нэрийдлээр маогийн дотоод бодлогын чиг шугамд зарим нэг засвар оруулсан боловч БНХАУ-ын гадаад бодлогын талаар ХКН-ын VIII их хурлаас дэвшүүлсэн зөв чиг шугамын тухай огт дуугүй өнгөрч, маогийн гадаад бодлогын чиг шугамыг өчүүхэн ч хөндөөгүйгээр үл барам зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг империалист хамгийн харгис хүчинтэй холболдон сүлбэлдэх, дайн түрэмгийллийг онцлон үзэх, зэвсэглэлээр улангасан хөөцөлдөх, хятадын их гүрний дээрэнгүй жанжлах үзлийг хэрэгжүүлэх шинж агуулгыг нь улам хүчтэй болгож байна.

Хуа Гофэн-Дэн Сяопин нарын бүлэг Мао Зэдүний «гэрээсийг» заавал мөрдөж, зөвлөлтийн «социал-империализмыг» эсэргүүцсэн тэмцлийг «эцэст нь хүргэх», БНХАУ-ыг империалист гүрнүүд, тэдгээрийн хамгийн харгис хүчнүүдтэй ойртуулан түншлүүлэх талаар бүхнийг хийж байна.

Хятадын одоогийн удирдлагын энэ бодлогод АНУ, Япон, Умард Атлантын цэргийн эвслийн орнуудтай харилцаа холбоог Зөвлөлтийн эсрэг, социализмын эсрэг үндсэн дээр өргөтгөн хөгжүүлэх явдал гол суурь эзэлж байна. 1978 оны намар Хятад-Японы хооронд байгуулсан «Энх тайван, найрамдлын гэрээ» гэгчид Хятадын тал ЗХУ болон Азийн бусад социалист орны эсрэг эвсэлд Японыг татан оруулах зорилго бүхий «жанжлалын эсрэг тэмцэх» тухай зүйл шургуулж 1979 онд Дэн Сяопин АНУ, Японд, Хуа Гофэн ХБНГУ, Англи, Франц, Италид очиж хэлэлцээр хийсэн нь бээжингийн эрх баригчид социалист хамтын нөхөрлөлийн эсрэг «Вашингтон-Бээжингийн холбоо» тогтоож түүнийг «Вашингтон-Бээжин-Токиогийн тэнхлэг» болгон өргөжүүлж байгуулах үндэс суурийг тавьж, Социалист Вьетнамын эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдэх, Умард Атлантын цэргийн эвслийн орнуудтай нягт харилцаатай болох, тэднийг ЗХУ болон Варшавын гэрээний орнуудын эсрэг улам турхиран цэрэг зэвсэглэлээ хүчтэй болгохыг ятган, өдөөн хатгах зорилго агуулжээ. Бээжингийн удирдлага Зүүн өмнөд Ази болон Энэтхэг-Хятадын хойгт хятадын жанжлалыг тогтооход Нэгдмэл Социалист Вьетнам Улс саад болж байна гэж үзэн ядаж, Америк, Японы империалист харгис эрх баригчидтай урьдчилан хэл амаа ололцож тохиролцсоны дараа түүний эсрэг зэвсэгт түрэмгийлэл үйлдсэнээр өөрсдийгөө дэлхийн социализм, улс түмний энх тайван, аюулгүй байдлын заналт дайсан болохоо илт харуулав. Хятадын ноёрхол, маогийн «цэргийн хуарангийн дэглэм» чухам юунд хүргэж болдгийг Кампучид гурван жил эзэгнэхдээ түүний 8 сая хүн амын 3 саяын амь насыг бүрэлгэснээс тодорхой харж болно. Бээжингийн дайны хэнээтнүүд Кампучид тэдний гар хөл болж байсан Пол Пот-Йенг Сарийн дэглэм нуран унаж хувьсгалт байгуулал тогтсонд хийгээд Вьетнамд шившигтэйгээр ялагдсандаа уур хилэн нь бадарч, одоо БНСВУ, БНАЛАУ-ын хилийн дагуу үлэмж их цэрэг зэвсгийн хүч дахин бөөгнөрүүлэн, Вьетнамд «дахин сургамж өгнө» гэж хашгирч, тэдгээрийн эсрэг зэвсэгт өдөөн хатгалга хийсээр байна.

Хятадын эрх баригчид Ази, Африк, Латин Америкийн орнуудын ард түмний заналт дайсан болохоо өөрсдийнхөө өдөр дутмын явууллагаар улам бүр нотлон харуулж байна. Маогийнхны адал балмад чиг шугамыг

баримталбал ямар их гунигт байдалд ордгийг 1965 онд Индонезийн Коммунист намд тохиолдсон хэрэг явдал тод гэрчилж байгаа юм. Тэд Чилийн фашист хунтынхан, Өмнөд Африкийн арьсны үзэлтнүүд, Израилийн дайнчид, Арабын харгис дэглэмийн явууллагыг дэмжин, эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн, олон улсын болон тив районуудын дэвшилтэт ардчилсан байгууллагуудын үйл ажиллагаанд элдэв саад бэрхшээл учруулж, хагалан бутаргах явууллага хийсээр байна.

Бээжингийн их гүрний жанжлах дээрэнгүй үзэлтнүүд социалист орнуудыг хагалан бутаргах зорилгоор ялгавартай хандан, БНМАУ, Социалист Кубыг үзэн ядаж, Африкийн социалист чиг баримжаагаар хөгжиж буй орнууд болон Ардчилсан Афганистаны эсрэг хорлон сүйтгэх явууллагаа идэвхжүүлж, Энэтхэг болон Азийн бусад оронд төрөл бүрийн дарамт шахалт үзүүлж байгаа юм.

Дэлхийн дэвшилт хүчний дэмжлэгтэйгээр БНХАУ-ын хууль ёсны эрхийг НҮБ-д сэргээсэн явдлыг Хятадын маоист удирдлага социализмын эсрэг их гүрний жанжлах бодлогоо хэрэгжүүлэх, дэлхийн хамгийн харгис хүчинтэй эвсэж хуйвалдах талбар болгон ашиглахыг хичээж байна. Олон улсын намжмал байдлын үйл явцыг гүнзгийрүүлэх, цэрэг зэвсгийг хорогдуулж зэвсэг хураах, цөминн зэвсэггүй орнуудын аюулгүй байдлыг баталгаатай болгох зэрэг амин чухал асуудлаар НҮБ-д Хятадын төлөөлөгчдийн баримталж буй байр суурь нь империалист хамгийн харгис эрх баригчдынхаас өчүүхэн ч ялгагдахгүй, улс түмний энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны эсрэг чиглэж байна.

Хятадын эрх баригчид олон улсын намжмал байдлын чухал үе болсон стратегийн зэвсгийг хориглох тухай ЗХУ, АНУ-ын хооронд байгуулсан хоёр, дахь хэлэлцээрийг илт эсэргүүцэн, энэ хэлэлцээр өрнөдийнхөнд «юу ч авчираагүй», харин тэдэнд «зөвлөлтийн аюул заналхийлж байгаа» мэтээр ярьж, түүний түүхэн ач холбогдлыг гуйвуулан үгүйсгэж байна.

Бээжингийн удирдагчид империалист гүрнүүдийн хамгийн харгис эрх баригчидтай түншлэхдээ тэднийг дэлхийн социализмын эсрэг дайнд яаравчлан бэлтгэх, цэрэг, зэвсгээ эрс нэмэгдүүлэхийг зөвлөн, Умард Атлантын цэргийн түрэмгий эвслийг улам бэхжүүлэх, Өрнөд Европын орнуудын нутагт «Першинг 2», далавчит пуужин зэрэг дунд тусгалын пуужин-цөмийн шинэ зэвсгийг АНУ байрлуулах гэж байгааг сайшаан дэмжиж буй нь Европ болон дэлхий дахины нийт улс түмний энх тайван аюулгүй байдалд заналхийлсэн нэн осолтой бодлого юм.

Хятадын эрх баригчид дэлхийн II дайны үр дүнг хянаж үзэх, дэлхийн улс төрийн зургийг дахин өөрчлөхийг эрмэлзэж буй өш хонзон өвөрлөгч милитаристуудын ойр дотно хамсаатан нь болж байна. Түүгээр ч үл барам тэд өөрсдөө эцсийн эцэст дэлхийг эзлэн ноёлох санаархалтай байдгаа илт ярьж, юуны өмнө Хятадтай хөрш зэргэлдээ оршдог ЗХУ, Монгол, Вьетнам, Энэтхэг, Бирм зэрэг олон орны газар нутгийн хэсгийг нь буюу зарим орныг бүхэлд нь эзлэн авах өнгөлзлөг хийж байна.

БНМАУ-ын талаар Мао болон түүнийг залгамжлагчдаас баримталж ирсэн бодлого бол монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтносон хөгжлийг устгаж, манай орныг Хятадад хавсарган нийлүүлэх чиг шугам баримталж байгаа явдал юм.

Хятадын удирдагчид манай улсыг эзлэн авахад давагдашгүй бартаа болсон монгол-зөвлөлтийн ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг нүд үзүүрлэн харааж, түүнийг дайсагнасан зүсэн бүрийн хорт явууллага үйлдэж байна. Тэд их гүрний дээрэнгүй эзлэн түрэмгийлэх бодлогоо манай улсын хувьд хэрэгжүүлэхийн гол нөхцлөө хангах зорилгоор БНМАУ-аас зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргах зүй бус шаардлага тавьж байна. Зөвлөлтийн цэргийн ангиуд БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд 1966 онд байгуулсан найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах гэрээний да-

гуу манай улсын засгийн газрын хүсэлтээр тус оронд байрлах болсон шалтгааныг зааж, 1978 оны 4-р сард БНМАУ-ын засгийн газраас БНХАУ-ын засгийн газарт өгсөн нотод: «Үүний учир шалтгаан бол Хятадын эрх баригчдаас БНМАУ-ын талаар явуулж буй бодлогод л байгаа юм. Өөр шалтгаан байхгүй»¹ гэжээ.

Хятадын удирдагчид 60-аад оны эхэн үеэс эхлэн манай улсын хилийн дагуу цэрэг бөөгнөрүүлэн, монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолд шууд заналхийлэх болсон юм. Одоо ч гэсэн тэд манай улстай хил залгадаг районуудад их хэмжээний цэрэг, зэвсгийн хүч бөөгнөрүүлж, цэрэг стратегийн янз бүрийн барилга байгууламж барьж, зам гүүр тавьж, хил рүү харилцаа холбооны шугам барьж байгуулан, манай улсын халдашгүй дархан хил хязгаарыг зөрчих явууллага хийсээр байна.

Сүүлийн үед хятадын их гүрний үндсэрхэг дээрэнгүй жанжлах үзэлтнүүд түүхийн баримтыг гуйвуулж, манай улсыг түүхийн үүднээс Хятадын салшгүй хэсэг байсан мэтээр нотлохыг оролдсон олон ном, өгүүллийг ч гаргах болов.

Бүрэн эрхт, тусгаар тогтносон социалист Монгол улсыг түрэмгийлэн эзлэх гэсэн бээжингийн эрх баригчдын санаархал биелэх тавилангүй юм. Учир нь тэдний энэ замд юунд ч үл давагдах хамгийн лут хүч болсон монгол-зөвлөлтийн ард түмний мөнхийн эвдэршгүй, гүн зузаан найрамдал, хамтын ажиллагаа байгаа юм.

БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бээжингийн эрх баригчид бодитой заналхийлж байгаа одоо үед монголын ард түмэн өөрийн шалгарсан дотны анд ЗХУ-ын ах дүүгийн өгөөмөр тусламж дэмжлэгт улам их түшиглэх нь мэдээж юм. Үүнтэй холбогдуулан МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга нөхөр Ю. Цэдэнбал МАХН-ын Төв Хорооны VI бүгд хурал дээр хэлэхдээ: «Энэ аюул занал арилаагүй цагт бид өөрийн социалист эх орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах үйлсдээ урьдын адил Зөвлөлт Холбоот Улсын үр бүтээлтэй тусламжийг авах явдал зүй ёсны хэрэг юм»² гэсэн билээ.

Монголын ард түмний хамгийн нандин хувьсгалт ололтын нэг болсон Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг эвдэн бусниулж таслах гэсэн бээжингийн эрх баригчдын хорон санаа бүхий элдэв оролдлого, гүтгэлэгт манай улс тухай бүр няцаалт өгөхийн зэрэгцээ БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох, хамтын ажиллагаа, сайн хөршийн байдлыг сэргээх талаар МАХН-ын XVII их хурал, түүнээс хойш хуралдсан намын төв хорооны удаа дараагийн бүгд хурлаас дэвшүүлсэн заалтыг тууштай баримталж байна.

Хятадад Ардын хувьсгал ялж, БНХАУ байгуулагдсанаас хойш хятадын ард түмний туулж өнгөрүүлсэн 30 жил нь утга агуулга, үр дүн, хор уршгаараа эсрэг тэсрэг хоёр өөр үе болж байна. БНХАУ байгуулагдсаны дараах эхний 10 шахам жилд ХКН үйл ажиллагаандаа үндсэндээ марксизм-ленинизмын зарчмыг баримтлан, социалист байгуулалтын ерөнхий зүй тогтлыг өөрийн орны өвөрмөц ноцолд тохируулан хэрэглэж, БНХАУ социалист хамтын нөхөрлөлийн орнуудтай нэг эгнээнд мөр зэрэгцэн явж байсан үед улс орны хөгжил урагшлан, БНХАУ, ХКН дэлхийн социализм болон хувьсгалт хөдөлгөөний үйл хэрэгт зохих хувь нэмэр оруулж байв. Харин Хятадын удирдлага 1958 оноос эхлэн сүүлийн 20 гаруй жилийн турш марксизм-ленинизм, социалист интернационализмын зарчмаас бүрмөсөн ухарч, үйл ажиллагаандаа маоизмын харгис үзэл, их хан үндэстний дээрэнгүй жанжлах эзлэн түрэмгийлэх үзлийг удирдла-

¹«Үнэн», 1979 оны 4-р сарын 20.

²«Үнэн», 1979 оны 11-р сарын 20.

га болгосноор хятадын ард түмний социалист ололт үрэн таран болж, БНХАУ-д социализм байгуулж байсан урагшлах хөдөлгөөн тасалдан, улс орны нийгэм-эдийн засгийн томоохон нэг ч асуудал нааштай шийдвэрлэгдээгүйгээр үл барам бээжингийн эрх баригчид дэлхийн социализм, олон улсын коммунист, ажилчны болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, энхийг эрхэмлэгч бүх дэвшилт хүчнийг эсэргүүцсэн империалист хамгийн харгис хүчний ойр дотно холбоотон болж хувирав. Харгис маоизм Хятад орноор барахгүй дэлхийн социализм, хувьсгалт хөдөлгөөн, энх тайвны үйлсэд тоо тоймшгүй их хор хохирол учруулсаар байна.

БНХАУ байгуулагдсанаас хойш хятадын ард түмний туулж өнгөрүүлсэн 30 жилийг бүхэлд нь авч үзвэл, хэрэв их бага аль ч орны засгийн эрхэнд байгаа Коммунист нам үйл ажиллагаандаа социалист байгуулалтын ерөнхий зүй тогтлыг өөрийн орны өвөрмөц нөхцөлд тохируулан хэрэгжүүлбэл сайхан амжилтанд хүрч болдгийг БНХАУ байгуулагдсаны дараах эхний 10 шахам жилийн хөгжил дэвшил, харин марксизм-ленинизмийн сургаалаас урваж жижиг хөрөнгөтний үндсэрхэг дээрэнгүй жанжлах үзэлд автагдвал чухам ямар шүү хүнд бэрх байдалд орж болохыг БНХАУ-ын сүүлийн 20 гаруй жилийн хэрэг явдал, түүний өнөөгийн бодит байдал тод харуулж байна.

С. Ишдорж

30 ЛЕТ КНР И ЕЕ СОВРЕМЕННОЕ ПОЛОЖЕНИЕ

Р е з ю м е

В статье анализируются два совершенно противоположных по своему содержанию и итогам периода развития КНР и соответственно ее внешняя политика. В первый период (1949—1957 гг.) когда КПК в своей деятельности в основном руководствовалась марксизмом-ленинизмом и общими закономерностями социалистического строительства, когда Китай шел в одном ряду с СССР и другими социалистическими государствами, китайский народ добился больших успехов в осуществлении революционно-демократических преобразований и строительстве основ социализма в стране. Возрастал международный авторитет КНР. Рассматривая первый период, автор подчеркивает историческое значение советско-китайского договора о дружбе, союзе и взаимной помощи (февраль 1950 г.) и VIII съезда КПК (1956 г.) для социалистического развития Китая.

По мнению автора, второй период начинается с 1958 г., когда маоист-маоистское руководство приступило к реализации политики «трех красных знамен», Маоистской «генеральной линии», «большого скачка» и «народной коммуны». И с этого жепериода начинается курс на форсированную милитаризацию страны и превращение Китая в милитаристское агрессивное государство. Во внешней политике пекинское руководство приступило к политике разрыва дружественных отношений с СССР и другими братскими социалистическими государствами, свертыванию экономических и культурных связей с ними. Оно также выступило с особой антимарксистской программой («Предложение генеральной линии международного коммунистического движения»), основывающейся на отрицании руководящей роли мировой социалистической системы международного рабочего класса. Эта

программа подменяла классовые противоречия в современном мире националистическими и расовыми антогонизмами. Мао Цзедун и его сторонники перешли к открытым раскольническим действиям в международном коммунистическом движении, насаждая антимарксистские, пропекинские группировки в рядах коммунистических партий.

Внутри страны китайское руководство развернуло массовую, антисоциалистическую, террористическую кампанию под флагом «культурной революции», в ходе которой была разрушена народно-демократическая общественная надстройка, и власть перешла в руки военно-бюрократического аппарата личной диктатуры Мао-Цзедуна.

IX съезд КПК (апрель 1969 г.) узаконил политический переворот, совершенный «культурной революцией» и, основываясь на троцкистской теории «перманентной революции», снял по существу вопрос о построении социализма в Китае. Вместе с тем съезд возводил антисоветизм в ранг государственной политики КНР.

К началу 70-х годов в маоцзедуновском руководстве КНР взяла вверх тенденция на открытое сближение с крупными империалистическими державами, в первую очередь с США и Японией. Анализ экономики Китая при Мао Цзедуне показывает, что развитие народного хозяйства КНР задержалось на 10—15 лет. Маоизм в практическом и теоретическом плане оказался в глубоком кризисе.

Пришедшее к власти после Мао нынешнее руководство КНР во главе с Хуа Гофэном, объявив себя «истинными наследниками Мао», внеся некоторую корректировку в маоцзедуновские установки, приступило к осуществлению так называемой политики «четырёх модернизаций». Основная цель этой политики заключается в создании крупной военно-промышленной базы путем тотальной мобилизации материальных и людских ресурсов страны. Курс Пекина на использование многомиллиардных займов ведущих капиталистических государств для модернизации промышленности и оснащения армии современным, дорогостоящим оружием не только задерживает развитие важнейших отраслей народного хозяйства КНР, но и ставит ее экономику в прямую зависимость от иностранного капитала.

XI съезд КПК (август 1977 г.) и последовавшие за ним пленумы ее ЦК, сессии ВСНП 3-го созыва подтвердили и еще более углубили антисоциалистический, гегемонистский, внешнеполитический курс КНР, направленный на срыв разрядки международной напряженности. Антисоветизм был объявлен главным направлением внешней политики КНР. Под антисоветизмом маоистов следует понимать антисоциалистическую кампанию пекинских лидеров.

В статье подвергаются критике внешнеполитическая деятельность Пекина на международной арене, вооруженная агрессия правящих кругов Китая против социалистического Вьетнама весной 1979 года, их провокации против СРВ и ЛНДР, а также разоблачается антимоногонгольская политика и деятельность нынешнего китайского руководства.

В заключение автор, подводя итоги 30-летнего периода развития КНР, подчеркивает, что теория и практика маоизма причинили и продолжают причинять огромный ущерб не только национальным интересам самого Китая, но и делу мирового социализма, национально-освободительного движения, интересам всеобщего мира и безопасности народов.